

ТҮҮХ

**МАНЖ ЧИН УЛСААС МОНГОЛ  
ДАХЬ ХЯТАДЫН ХУДАЛДАА  
МӨНГӨ ХҮҮЛЛИЙН ТАЛААР  
ЯВУУЛСАН БОДЛОГО  
(1691—1911)**

**А. Очир**

Монгол оронд XVII зууны ерээд оноос Хятадын худалдаа-мөнгө хүүллийн капитал нэвтэрч, улмаар Монголын зах зээлийг эзлэн авч, XX зууны эхэн хүртэл Монголын ард түмнийг эдийн засгийн талаар боолчлон мөлжиж байсан нь чухамдаа Манжийн колонийн дарангуйллын хамгийн уршигт үр дагавар байжээ. Монгол дахь Хятадын худалдаа-мөнгө хүүлэл, Хятад тариачдын талаарх Манжийн төрийн бодлого нь Монгол орныг колоничлох эдийн засгийн бодлогынх нь нэг бүрэлдэхүүн хэсэг болж байв.

Монгол дахь Хятадын худалдаа-мөнгө хүүлэл, хятад тариачдын талаархи Манжийн засгийн газрын бодлогыг шинж чанараар нь хоёр үндсэн үед хувааж үзэж болно.

НЭГДҮГЭЭР ҮЕ НЬ Монголчууд Манжийн эрхшээлд орсон 1690 ээд оноос XIX зууны тэргүүн хагасыг хамарна<sup>1</sup>. Энэ зуун тавь гаруй жилийн туршид Манж нар Хятадын худалдаачид, тариачдыг Монголд бөөнөөр нь оруулахгүй, тодорхой хэмжээнд хязгаарлан барьж байхад чиглэсэн бодлого явуулжээ. Манжийн засгийн газрын энэ бодлого нь тэр үед Чин гүрний колони болон хараат байдалд оршиж байсан олон орны ард түмнийг эрхшээлдээ байлгаж, дарлан мөлжиж байх гэсэн улс төрийнх нь ерөнхий чиг шугамтай холбогдсон хэдэн шалтгаантай байв.

Манжийн байлдан дагуулагчид цэрэг, зэвсгийн хүчээр байгуулсан Чингийн эзэнт гүрний бүрэлдэхүүнд Ази тивийн олон угсааны ард түмэн багтаж байв. Нийгмийн үйлдвэрлэх хүчин нь сул дорой, хүн ам цөөнтэй манж нар өөрсдийн ноёрхлоо тогтоож байхын тулд тэдгээр ард түмний эрхэлсэн аж ахуй, амьдралын хэв маяг, шашин шүтлэгийн байдал, түүгээр ч үл барам бүр газар нутгийн нь байрлалыг түрэмгий эрх ашигтаа зохицуулан ашиглах болжээ. Тэрчлэн тэдгээр ард түмнийг бас тусад нь түгжигдмэл байлгаж, бие биеийн нь эсрэг тавьж, нэгнийх нь тэмцэл хөдөлгөөнийг нөгөөгийнх нь цэрэг, эдийн засгийн хүчээр дарахыг зорьж байв. Хэрэв тэдгээр ард түмнийг хооронд нь ойртуулбал бие биетэйгээ танилцаж, өөрсдийнхөө дайсныг ойлгож, Манжийн эсрэг хамтран босч болзошгүй байв. Тийм учраас Хятад, Монголын ард түмнийг хооронд нь ойртуулахгүй, хөндий байлгахыг хичээж байснаас хятад худалдаачид тариачдыг монголд олноор оруулахыг хоригложээ.

Бас нэг шалтгаан нь Монголыг колоничлох манжийн эдийн засгийн бодлоготой шууд холбоотой. Хятадын худалдаа-мөнгө хүүлэгчид Монголд олноор орвол, монголчуудыг мөлжих нь үлэмж нэмэгдэж, монголын эдийн засаг хэтэрхий доройтоод, монголчууд Манжийн олон зүйлийн хүнд алба татварыг цаг хугацаанд нь залгуулж чадах

гүйд хүрнэ. «Түүгээр ч үл барам уур хилэн нь бадарсан монголчууд Манжийн эсрэг босч тэмцэж, тэдний ноёрхолд хохирол учруулж болох»<sup>2</sup> байжээ.

Нөгөө талаар тэр үед Манж Чин гүний захиргаанд байсан ард түмнүүдийн дотроос мал аж ахуйн хөгжлийн төвшин, сүргийн зохистой бүтэц, малыг өсгөн үржүүлэх, эдэлж ашиглах талаараа монголчууд арай илүү байсан төдийгүй, мал өсгөж үржүүлэхэд хамгийн тохиромжтой бэлчээр нутаг ч монгол орон байжээ. Тийм учраас, Монголын ард түмнээс дээрэмдэн авсан Манжийн хааны сангийн үржил сүрэг, манжийн дарангуй цэргийн зүтгэх хүчний бэлтгэл малын ихэнх хэсгийг монголд адгуулан үржүүлж байжээ. Бас Манжийн хааны ордны хамгаалалтын цэргийн уналгын агтыг монголоос жил бүр татварлан авч сэлбэдэг байв. Өөрөөр хэлбэл, Монгол орныг Манжийн цэргийн зүтгэх хүчийг сэлбэж, уналга хэсгийг нийлүүлэх нэг бааз болгон ашиглах бодлого явуулжээ. Хэрэв Монголд хятад тариачдыг олноор оруулан тариа тариулбал бэлчээр хомсдохоос гадна Монголын нүүдэл амьдралд нөлөөлж болох байжээ.

Эдгээр учир шалтгааны улмаас Манжийн эрх баригчид XVIII—XIX зууны дэд хагас хүртэлх хугацаанд Монголын хуучин эдийн засгийн байгуулал, нүүдэл амьдралыг төдий л хөндөлгүй хэвээр нь байлгах бодлого явуулж, Халх Монголыг «**Хааны цаазат бэлчээр**» хэмээн нэрлэж байв. Гэтэл Хятадын худалдаачид-мөнгө хүүлэгчдийг Монголд ерөөсөө нэвтрүүлэхгүй байх нь Манжийн колоничлогчдын эрх ашигт бас харшлах байжээ. Учир нь: Нүүдлийн мал аж ахуйтай монголчууд суурин орны бүтээгдэхүүнийг авахыг эрмэлзэж байдгийг дээр дурдсан билээ. Хэрэв монголчуудыг Хятадын зах зээлээс бүр мөсөн тасалбал, тэд хөрш Оросой ямар нэг хэлбэр, хэмжээгээр худалдаалахад зайлшгүй хүрнэ. Энэ нь Монгол Оросын ард түмэн хоорондоо ойртох, Оросын нөлөө Монголд дэлгэрэх, Монголын мал, түүхий эд Оросод гарах болно гэсэн үг юм. Хэрэв ингэвэл, Монгол орныг түгжигдмэл байдалд барьж, тэдний цэрэглэг чадвар, эдийн засгийн чадавхийг ашиглан эрхшээлдээ байсан бусад ард түмний тэмцэл хөдөлгөөнийг даруулж байх гэсэн манжийн бодлого, эрх ашигт туйлаар харшлах байв.

Бас Монголд Хятадын худалдааг нэвтрүүлэх нь Манжийн хааны санд гаалийн татвараар зохих орлого оруулахаас гадна Манжийн төрийн авлигач түшмэлүүдэд ашиг завшаан олох нэг нүх сүв нээгдэж байсан юм.

Тэрчлэн Монголоос гаргуулан авдаг Манжийн олон зүйлийн алба татварыг цаг тухайд нь шуурхай гүйцэлдүүлэхэд Хятадын худалдаа мөнгө хүүлэл зохих үүрэгтэй гэж тэд үзжээ<sup>3</sup>. Манжийн аливаа бачим түргэн албанд хэрэглэх бүх зүйлийг монголчууд хятад худалдаачдаас хүүтэйгээр зээлэн авч, дараа нь төлдөг бөгөөд Манжийн засаг захиргаа ч үүнийг албан ёсоор зөвшөөрч, хуулиар бататгажээ.

1696 онд Галдан бошготтой байлдах Манжийн их цэрэг Халх Монголын нутагт цөмрөн орж ирэхэд түүнийг дагалдан түрүүчийн хятад худалдаачид орж ирсэн байна<sup>4</sup>. Манжийн түрэмгийлэгчид Галдантай

2 М. Санждорж, Халхад хятадын мөнгө хүүлэгч худалдаа нэвтэрч хөлжсөн нь УБ., 1963. . 53-р тал.

3 М. Санждорж, дурдсан зохиол 27-р тал

4 Мөн тэнд 41-р тал

байлдаж их цэргийнхээ хүнс хэрэглэлийг хангах зорилгоор хятад худалдаачдыг эд бараатай нь Монголд оруулж ирсэн бөгөөд тэд Манжийн цэргийг дагалдан явж, аму будаа зэрэг хүнсний зүйлийг цэрэгт худалдаж байв. Их цэрэг Бээжингээс хөдлөхийн өмнө Манжийн засгийн газар зориуд мөнгө гарган аму будааны зүйлийг худалдан авахуулж бэлтгүүлээд, цэрэг явах замын дагуу газруудад зөөн аваачаад, цэргүүдэд хятад худалдаачдаар худалдаалуулж байв. Тэгэхдээ «цэрэг аму хоёрыг эрхгүй нэгэн хүн шийтгэсэн нь сайн»<sup>5</sup> хэмээн аму будаа зөөх тээвэрлэх, худалдаалуулах ажлыг цэрэг удирдсан жанжин нарт давхар даалган хариуцуулжээ. Манж нар Монгол орныг түрэмгийлэх цэргийнхээ хүнс тэжээлийг хангахдаа, Хятадын мөлжмтгий худалдаачдыг ашигласан нь амжилттай болсон учир Энх амгалан хаан «Би их цэргийг авч замаар орохуйд ... будааг илүү бэлтгүүлэх тулд хэдий (цэргийн) хороог дагалдан худалдаалан явах хүн хэмээвч цөм амуд гачигдсан газаргүй ... Үүнээс хойш цэрэглэн явах газар буй аваас үүнийг үүрд дүрэм болговоос зохино»<sup>6</sup> хэмээн зарлиг буулгажээ. Манж нар дараа нь Зүүнгар Уйгурыг байлдан эзлэхдээ ч энэ зарлиг ёсоор түрэмгий цэргээ дагалдуулан хятад худалдаачдыг оруулснаар тэнд хятадын худалдаа нэвтэрсэн байна.

1696 онд Халх Монголд орж ирсэн Манжийн цэрэг Галдан бошготыг дарсныхаа дараа нэлээд нь Халхад үлдээд, Монголчуудын Манжийг эсэргүүцсэн аливаа бослого хөдөлгөөнийг нухчин дарах, Халхтай шууд хил залган оршиж байсан Зүүнгарын хант улс халхыг эзлэн авах, халхчуудыг тэдэнтэй нэгдэхээс хамгаалах нэрийдлээр хэдэн газар цэргийн хот байгуулан суужээ.

Орхон, Тамир, Туул, Хар ус, Цагаан сүүл зэрэгт байрласан Манжийн цэргийн хуаран хот нь хятад, монголчуудын байнга худалдаалах газар болов. Манжийн засгийн газар тухайн үедээ тэдгээр цэргийн хотыг хятад, монголчуудын худалдаалах газар гэж албан ёсоор зарлаагүй боловч хэрэг дээрээ зөвшөөрсөн нь чухамдаа Монголд байр сууриа бэхжүүлэхэд Хятадын худалдааг ашиглахыг зорьсных юм. Тэр үед Оросын худалдаачид Монголд нэлээд ирж худалдаалдаг байсан учир түүнийг шахахын тулд хятад худалдаачдыг Их хүрээ зэрэг суурин газраар худалдаалуулах шаардлагатай гэж үзжээ. Тийм учраас Монголд Хятад худалдаа нэвтэрснээс хойших хориод жилд тэднийг хязгаарласан хууль гаргасангүй. Харин Манж нар Хятад болон Монголд байр сууриа бэхжүүлж, Монгол дахь оросын худалдааг нэлээд шахсаныхаа дараа сая 1720 онд тусгай хууль гаргаж, Монголд одох бүх худалдаачид Гадаад Монголын төрийг засах явдлын яаманд заавал биеэр одож зөвшөөрлийн тэмдэгт бичиг авдаг болгов. Тэгэхдээ нэг худалдаачинд жилд нэг тэмдэгт бичиг олгох бөгөөд тэр нь хориос илүүгүй тэрэг ачаа, арваас илүүгүй хөлсний хүнтэй явахыг зөвшөөрчээ. Мөн 1726 онд худалдаачдын бараанаас үнийн 5%-иар гааль хураах болгожээ. Гаалийн татварын орлогыг 4000 лангаар төсөвлөн бодож байснаас үзвэл, XVIII зууны эхэн хагаст Халхад худалдаалах барааны үнийг 80—100 мянган лангаар багцаалан зөвшөөрч байсан бололтой. Гэвч Ар монгол дахь Хятад худалдаачдын тоо байнга өссөөр байсан учир 1719 онд Их хүрээнд

5 Богд сургаал, Л. Дэндэвийн орчуулга, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн хөмрөг, 1-р дэвтэр

6 Мөн тэнд

худалдаачдын хэргийг тусгайлан эрхэлсэн Журганы зангийн газар, 1727 онд Хиагтын заргачийн газар байгуулжээ. Өөрөөр хэлбэл Их хүрээ, Хиагтын наймаачинг буй болгожээ. 1737 онд Их хүрээнд монгол цэрэг гаргаж, хятад худалдаачдыг харгалзуулан хамгаалуулсан байна. Гэвч хятад худалдаачдын тоо жилээс жилд өссөөр байсан тул 1751 — 1757 онд Манжийн засгийн газар хэд хэдэн хууль, дүрэм гаргаж, тэдний худалдаалах журмыг шинэчлэн тогтоожээ. Тэр хууль ёсоор, Халхад ирсэн худалдаачид Гадаад Монголын төрийг засах явдлын яамнаас авсан тэмдэгт бичгээ Их хүрээ, Хиагтын Журганы зангид шалгуулж хураалгаад, тэндээс дахин монгол үсгийн бичиг авч худалдаалаад буцахдаа түүнийгээ хураалгаж, анх авчирсан тэмдэгт бичиг дээрээ хэрхэн худалдаалсан тухай тэмдэглүүлдэг болжээ. Мөн аймаг хошуудад явж худалдаалахыг хатуу хориглож, хэрэв өр нэхэхээр явбал гэр барьж байрлахгүй зөвхөн майханд суухаар болгож, монгол эхнэр авах, монгол айлд хонохыг зөвшөөрөөгүй байна.

Түүнчлэн Засагт хан аймаг Улиастай, Сайн ноён аймаг Орхон, Хар усанд, Түшээт хан аймаг Их хүрээнд, Сэцэн хан аймаг Долон нуурт тус тус худалдаалж байхаар тогтоожээ. 1777 оноос эхлэн Хятадаас Ар Монгол дахь маймаачингуудад ирэх замын дагуу тусгай харуул гарган, худалдаачдыг замаасаа гажих, замдаа худалдаалахыг цагдуулжээ. Үүнийг «хашлага харуул» гэж нэрлэв. Энэ бүхэн нь Ар Монгол дахь хятад худалдаачдын тоо, үйл ажиллагааг зөвхөн тогтоосон хүрээнд барьж байхад чиглэсэн арга хэмжээ юм. Гэвч Монгол дахь худалдаа Манжийн төрийн эдгээр шахалт хавчилтанд төдий л сааталгүй, улам өргөжин тэлж, бэхжсээр байсан нь хэдэн шалтгаантай байв.

Худалдаачид Монголын мал, түүхий эдийг Хятадад аваачин, өндөр үнээр борлуулж, дундаас нь завшихын төлөө улайран хөөцөлдөж чадах бүхнээ хийж байв. Ялангуяа хошуудад одоо худалдаалбал, тэндээс мал, түүхий эдийг маш хямдаар авдаг байв. Монголчууд ч гэсэн орон нутгаасаа хол маймаачингуудад одсоноос, шууд нутагтаа худалдаалах нь явдал чирэгдэл багатай гэж үздэг байжээ. Нөгөөтэйгүүр Хятадаас ирдэг худалдаачид Монголын баруун, баруун хойд, төвд байсан маймаачинд хүрч худалдаалснаас Монголын өмнө, зүүн өмнө зүгийн хошуудад худалдсан нь зардал, хугацаанд хэмнэлттэй байлаа. Тиймээс тэд хошуудад худалдаалахын тулд Манжийн авлигач сайд, түшмэдэд хээл хахууль өгдөг бөгөөд үлэмж хахууль авсан түшмэл тэднийг хошуудад одохыг хориглох байтугай зарим үед хамгаалж хаацайлдаг байжээ.

Монголд Хятадын худалдаа хурдан хугацаанд өргөжсөн нөгөө нэг шалтгаан бол худалдааг зээлээр хийж байсан явдал мөн. Зээлийн худалдаа буй болсон нь тэр үеийн Монголд таваар мөнгөний харилцаа хөгжиж, төлбөрийн тусгай хэрэгсэл буй болоогүй байсантай холбоотой. Өөрөөр хэлбэл, гүйлгээний хэрэгсэлгүй (өөрийн мөнгөн тэмдэгт үгүй) монголчууд хэрэгцээт бараагаа худалдаачдаас мал, малаас гардаг түүхий эдээр сольж авахаас өөр аргагүй. Гэтэл малаас гардаг түүхий эд, бусад бүтээгдэхүүн нь улирлын шинжтэй байдаг бол гурил будаа, даавуу зэрэг авах зүйл нь байнга шаардагдана. Ийм тохиолдолд авах зүйлээ хүүтэй зээлдэхэд хүрдэг байжээ.

Манжийн засгийн газар ч үүнийг зөвшөөрч, худалдаачид монголчуудад бараагаа жилд 36 хувийн хүүтэй зээлдүүлж байхыг 1761 онд хуулиар бататгажээ. Зээлийн худалдаа цаашид хурдан дэлгэрч газар авахад Монголоос манж нарын авдаг олон төрлийн хүнд алба онцгой

түлхэц болжээ. Албаны хэмжээ их, залгуулах хугацаа ямагт тулгам байсан нь монголчуудыг хятад худалдаачдаас үлэмж зүйлийг өрдөн авахад хүргэнэ. Аливаа албыг шуурхай залгуулахын тулд монголчуудад худалдаачид зээл олгож, түүнийг хүүний хамт хэзээ ч алдахгүй нэхэж авч байхыг Манж нар хуулиар бататгасан нь чухамдаа тэд Монголд өөрсдийн эрх ашгаа хамгаалахдаа хятад худалдаачдын эрх ашгийг давхар хамгаалсан хэрэг байлаа. Манжийн алба XVIII зууны дундаас эрс ширүүсч, тогтмол албад бүрэн жигдэрсэн нь нэг талаар монголчууд худалдаачдад зээлийн өндөр хүүтэй асар их өр тавьж, мөлжигдөх нь нэмэгдэх, нөгөө талаар худалдаачид Монголын эдийн засагт нэвтэрч байр сууриа бэхжүүлэх замыг засч өгсөн байна.

Хятадын худалдаа Монголд бэхжихэд түүний зохион байгуулалт, үйл ажиллагааны хэлбэр нь зохих үүрэг гүйцэтгэжээ. XVIII зуунд тэд жижиглэн худалдаа хийж байсан нь таваар мөнгөний харилцаа хөгжөөгүй, үндэсний худалдаачид төрж гараагүй, зам харилцаа муутай, нүүдлийн мал аж ахуйтай Монголын нөхцөлд таарч байжээ. Эдгээр нөхцөл, шалтгааны улмаас Монгол дахь Хятадын худалдааг хэдхэн наймаачны хүрээнд барьж байх гэсэн Манжийн бодлого газар дээрээ тэр бүр биелэгдэхгүй задгайрч, Хятадын худалдааны нөлөө, хүрээ байнга өссөөр, XVIII зууны эцэс болоход хошуудаар хэсэж худалдаалах нь нэлээд түгээмэл болж, зарим хошуунд гэр барин суурьшиж эхэлжээ. Гэвч бүхэлд нь авч үзвэл, XVIII—XIX зууны тэргүүн хагаст суурин худалдаа голлож байсан бөгөөд явуулын болон хошуудын худалдааны хамрах нутгийн хүрээ нь хожмынхыг бодвол явцуу, тогтмол бус, нийт худалдааны мөлжлөгийн хэмжээ далайц нь бага байв. XVIII зуун бол Монгол дахь Хятадын худалдааны зохион байгуулалт, мөлжлөгийн үндсэн арга, худалдаалах хэлбэр нь бүрэлдэж, улмаар цаашид Монголын бүх нутаг дэвсгэрийг хамарсан далайцтай мөлжлөг явуулах замаа тавьж авсан үе нь юм.

Монгол дахь Хятадын худалдаа-мөнгө хүүлийн талаархи Манжийн бодлогын **хоёрдугаар үе** нь XIX зууны дундаас эхэлж, Чингийн эзэнт гүрэн нуран унасан 1911 он хүртэл үргэлжлэв. Энэ үед Монгол дахь Хятадын худалдаачдыг тодорхой хэмжээнд барьж зохицуулж байхад чиглэсэн Манжийн эрх баригчдын урьдын бодлого аажмаар суларсаар бүр эсрэг эргээд, эцэст нь Монголд Хятадын худалдаачид, цагаач иргэд, тариачдыг цутган оруулж суурьшуулахад шилжсэн байна. Манжийн энэ бодлого нь дэлхийн капитализм эрчимтэй хөгжиж, том капиталист улсууд гадаад зах зээлийн төлөө, дэлхийг хуваах, дахин хуваахын төлөө хүчтэй өрсөлдөх болсон хийгээд, Чингийн эзэнт улсын төвлөн суусан Хятад орны нийгэм-эдийн засагт гарсан өөрчлөлттэй холбоотой. Юуны өмнө Манж Чин гүрний төвлөн суусан Хятад оронд XIX зууны тэргүүн хагасын сүүлчээс дэлхийн том капиталист орнуудудаа дараа түрэмгийлэн өөрсдийн капиталгаа оруулж, тус орны эдийн засгийн гол өндөрлөгүүдийг гартаа авч, түүнийг хагас колонийн байдалд оруулснаар Чин улсын эдийн засгийн хямралыг гүнзгийрүүлжээ. Нөгөө талаар гадаадын капиталистуудыг эсэргүүцсэн дайнд Манж Чин улс удаа дараа ялагдаж, дайны болоод тэдгээр капиталистуудын мөлжлөгийг эсэргүүцсэн хятадын ард түмний босогчдын эвдэж сүйтгэсэн гадаадынхны үйлдвэр завод, төмөр зам, харилцаа холбооны хэрэгсэл зэргийн төлбөр XIX зууны сүүлийн хагаст байнга нэмэгдсээр байжээ. Манж нарын гадаадынханд тавьсан өр зээл ч өссөөр байв. Зарим тооцооноос үзвэл, Япон, Герман, Францтай хийсэн дайнд ялагдсаны төлбөр 1900 онд 450 сая ланд хүрч, гадаа-

дын капиталистуудын банкнаас авсан зээллэг 1885 онд 40 сая лан байснаа 1910 онд 700 сая лан болжээ. Гэтэл XIX зууны ерээд онд Манж Чин улсын нэг жилийн бүх орлого 15 сая фунт стерлинг байв.<sup>7</sup> Тийм нөхцөлд, Манжийн эрх баригчид эзэнт гүрнийхээ харъяаны жижиг улс орны эдийн засаг, газар нутгийн бүх нөөцийг шавхан дайчилж өөрийн байр сууриа өөд татах бодлого явуулсан байна. Тэдний үзэж байснаар нөөцийг нь шавхаж болох сул газрын тоонд Монгол, Манжуур зэрэг орж байжээ.

Нөгөөтэйгүүр дэлхийн капитализмын нөлөө хүрээ улам өргөжих дутам том капиталист орнууд Монголд тал талаас нь өнгөлзөх нь ихэсчээ. Ийм байдалд Монгол орныг урьдын адил түгжигдмэл барих аргагүй болжээ. Ялангуяа XIX зууны дэд хагасын эхнээс оросын худалдаа, нөлөө Монголд дэлгэрч, монголчууд оростой ойртох зам нээгджээ.<sup>8</sup> Иймд Манж нар Монгол дахь Оросын худалдаа, нөлөөг хаахын тулд Хятадын худалдаачид, тариачдыг олноор оруулах шаардлагатай гэж үзсэн байна.

XIX зуунаас эхлэн Хятадын нийгэм-эдийн засагт тавигдсан капиталист үйлдвэрлэлийн харилцааны эх үүсвэр нь цаашид дотоод, гадаадын нөлөөгөөр хөгжин, капиталист харилцаа өрнөж, үндэсний аж үйлдвэр, ажилчин анги, хөрөнгөтөн буй болсоор байжээ. Захиргаандаа байсан ард түмнийг түгжигдмэл байлгах гэсэн Манжийн улс төрийн бодлогын эдийн засгийн үндэс бологч эзэлхүүний аж ахуй тийнхүү задрахын хэрээр тариачдын задрал түргэсч, Хятадын үйлдвэр, газрын эзэд, түшмэд, худалдаачид ашиг хонжооны хойноос хөөцөлдөх нь нэмэгдэж, Монголын зах зээлийг бүрмөсөн эзлэн авч, бараагаа борлуулж хямд түүхий эд олж авахын төлөө тэмцэх болов. Тариачдын задрал хүчтэй болсны улмаас газаргүй, гар хоосончууд үй олноор буй болж, түүндээр XIX зууны сүүлчээр хятадын газар тариалангийн олон районд хүчтэй ган болсон нь ядуусын тоог улам нэмжээ. Давхар дарлалд үгүйрэн, уур хилэн нь бадарсан үгүйчүүд дотоод, гадаадын дарлагчдын эсрэг удаа дараа босон тэмцэх болов. Ядуусын энэ тэмцэлээс айсан Манжийн засгийн газар тэднийг намтгахын тулд эзэнт гүрний гадна доторхи аль чөлөөтэй газарт нутгийг түрж эзэмшүүлэхээр шийдсэн байна.

Эдгээр шалтгааны улмаас Чин гүрний эрх баригчид Монгол Хятадын худалдаачид, тариачдыг олноор нь шилжүүлэн суулгаж улмаар Монгол орныг хятадчилах бодлогод шилжжээ. Гэхдээ Монгол дахь хятад худалдаачид, тариачдын талаархи Манжийн урьдын бодлого XIX зууны яг дунд үеэс эрс эргэсэн мэтээр ойлгож үл болно. Манж нар Монгол дахь худалдаачдын тухайд урьдын хууль дүрмийг 1870-аад он хүртэл албан ёсоор халж өөрчлөөгүй бөгөөд харин түүний хэрэгжилтэнд тавих хяналт нь суларч, нэг хэсэг бараг зөнд нь орхисон юм. Энэ нь хэрэг дээрээ тэднийг Монголд нэвтэрч орохыг дураар нь тавьж зөвшөөрсөн хэрэг байв.

Тийнхүү 1870-аад оноос Хятад худалдаачид Монголд хэрэгцээ, чинээгээрээ худалдаалж, байшин, агуулах барихыг албан ёсоор зөвшөөрч, 1883 онд Монгол Манжуурт хятад тариачдыг зохион байгуулалттай бөөнөөр нь оруулж суурьшуулах товчоог Бээжинд байгуулсан байна.

7 Тихвинский В. К. Движение в Китае за реформы М., 1979. 151-р тал

8 Ш. Сандаг, Монголын улс төрийн гадаад харилцаа (1850-1919) УБ., 1979, 112-р тал

Энэ товчоо эрхлэн Хятадаас үй олон тариачид, цагаачдыг Замын үүдээр дайруулан Их хүрээ, Их хүрээнээс Сэлэнгийн чиглэлд дамжуулан өнгөрүүлэхэд зориулсан тусгай гэр, майхан бариулан, зам дайрсан нутгийн хошуудаас түшмэл цэрэг дайчлан гаргаж, тэднийг харгалзан өнгөрүүлэхийг даалган суулгасан байна. Монголд оруулж ирсэн хятад тариачдыг голдуу Монгол-Оросын хилийн дагуу суулгаж, газар хэмжээлэн олгож байв. Ингэхдээ манж нар Монголын тариа тарьж болох бүх газрыг бүртгэж, Засгийн газрынхаа мэдэлд аваад, нутгийн монголчуудыг үржил шим муутай газар руу шахжээ. 1911 онд Монголын хойд зүгийн хошуудаас 4905000 десятин газрыг дээрх товчооны мэдэлд аваад байжээ. Бас хятад иргэд дангаар буюу хоршиж гарьсан талбай 2023 хуваарь байв.<sup>9</sup> Урьд нь Хятад тариачдын тариалж байсан бүх газрыг тэдний мэдэлд бүрмөсөн шилжүүлж, түрээс бараг төлөхгүй болгожээ. Хятад худалдаачдыг дуртай газраа шинэ пүүс, дян буудлын газрууд байгуулахыг зөвшөөрч, буудал, пүүс байгуулсан газраас түрээс авдаг урьдын хуулийг хүчингүй болгов. Манжийн засгийн газар Монгол-Оросын хилийн дагуу газрыг хятад-тариачдаар чигжих энэ явууллагаа «Завсрыг дүүргэх» бодлого хэмээн нэрлэжээ. Энэ нь Оросын нөлөө Монголд нэвтрэхийг хаасан хориглолтын бүс байв. Манжийн төрийн энэ харгис бодлого, арга хэмжээний уршгаар XIX -- XX зууны заагт Монгол дахь хятад худалдаачдын тоо асар олширч, мөлжлөг нь эрс ширүүсч ард олны аж байдал, улам доройтов.

XX зууны эхээр Монголд 100 мянга орчим хятад байснаас 70 мянга нь худалдаа эрхлэгчид байжээ.<sup>10</sup> Тэр үед Монголын хүн ам 500 мянга орчим байсантай харьцуулахад энэ нь маш их тоо юм. Үй олон Хятадыг Монголд оруулан суурьшуулах энэ бодлогын цаана Монгол орныг бүхэлд нь хятадчилах гэсэн Манж Хятадын далд санаа нуугдаж байв. Манжийн засгийн газар 1905 онд Их хүрээ, Хиагт, Улиастайд гаалийн хороо байгуулж, худалдаачдын Монголоос авч байсан мал, түүхий эдээс үнийн 5%-иар бодож гааль хурааж эхэлсэн байна.

Архивын бүрэн бус мэдээгээр 1906 онд Түшээт хан, Сэцэн хан аймагт худалдаалагчдаас 65 мянган лан гааль хурааснаас үзэхэд 1,5 сая лангийн мал, түүхий эд худалдан авсан байна.

Мөн 1911 оноос худалдаачдын ачаа, бараа тээгчдээс татвар авахаар шийдвэрлэжээ. Энэ бүхэн нь Манж нар өдөр ирэх бүр доройтсоор асан эдийн засгаа өөд татах, ноёрхлоо яаж ийгээд тогтоож байх гэсэн оролдлого юм. Манжийн түрэмгийлэгчид ийнхүү анхнаасаа Монгол орныг гадаад ертөнцөөс тасархай бөглүү барьж, улс төрийн ноёрхлоо удаан хугацаагаар тогтоож дарангуйлахын тулд Хятадын худалдаа-мөнгө хүүллийг эдийн засгийн чухал хөшүүрэг болгон ашиглах бодлого явуулж, түүхэн тодорхой нөхцөлд тохирсон олон арга хэмжээ авч тэр бодлогоо хэрэгжүүлсээр байжээ.

9 Нацагдорж, Халхын түүх. УБ., 1963 102-р тал

10 И.М. Майский, Монголия накануне революции. М. 1959, 84 — 85-р тал